



## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ<sup>1</sup>



**Сайнбуянгийн Баасандорж**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн  
231-р дамжааны сонсогч

**“Хайраар бялхсан хурим, итгэлээр дүүрэн гэрлэлт  
бүхэн гагнаж цутгасан ган болдноос ч илүү  
бат бөх байх болтугай”.**

**Судалгааны хэрэгцээ шаардлага:**

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаанд суурилсан эрх зүйн шинэтгэл Монгол улсад сүүлийн 15 жилд хийгдэж өнөөч үргэлжилсээр байна. Шинэтгэлийн үр дүнд Монгол улсад хүний эрхийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдсэн. Гэхдээ үүнийг хараахан эрх зүйт төрийн шаардлагад нийцсэн хүний эрхийг хамгаалах тогтолцоотой болсон гэж үзэх боломжгүй юм. Эрх зүйт ёсны гол зорилго бол хувь хүнийг хамгаалах явдал юм.

Бид төрөлх Монгол орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах эрх зүйт төрийг төлөвшүүлэх эрхэм зорилгыг Үндсэн хуульдаа тунхагласан билээ. Өнөөдөр хүний эрх олон янзын хэлбэрээр зөрчигдөж байгаа бөгөөд түүний дотор гэр бүлдэх гишүүдийн эрх далд нууц хэлбэрээр хамгийн их зөрчигдөх болсон байна.

Монголчууд “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэлцдэг нь нийгмийн хөгжилд хэн хувь нэмэр оруулах, энэ үйл явцыг хаанаас, ямар дарааллаар хувь хүн жолоодох ёстойг тун оновчтой тодорхойлсон гэж болно.

Гэр бүл өөрөө хүний хөгжлийг анхдагч орчин. Гэтэл гэр бүлийн нэг гишүүн нь нөгөөгийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчиж, махбод, сэтгэл санаа, бэлгийн болон эдийн засгийн хүчирхийлэл, дарамтанд оруулах явдал нийгмийн эмзэг асуудал, асар их хор уршиг бүхий сөрөг үзэгдэл болоод байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, энэ сөрөг үзэгдлийн хохирогч нь ихэнхдээ эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настангууд болж байдгийг олон улсын байгууллагуудын албан ёсны баримт бичигт цөөнгүй дурдсан байдаг.

<sup>1</sup> Их дээд сургуулийн сонсогч, оюутнуудын дунд зохион байгуулагдсан “Хуулийн оюутан-2012” эрдэм шинжилгээний хуралд тэргүүн байрт шалгарсан илтгэл



Хүний эрхийг хангах баталгаа түүнийг бүрэн хэрэгжүүлж чадах төр бол эрх зүйт төр гэж хүн төрөлхтөн бүгд санал нэгдэх байх.

Гэр бүлийн хүчирхийлэл Монгол орны хувьд ч түгээмэл байгаа бөгөөд сүүлийн үеийн судалгаагаар нийслэлийн анхан шатны шүүхээр таслан шийдвэрлэсэн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 20 орчим хувь нь гэр бүл, ахиун хүрээндэх хүчирхийлэлтэй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гарсан аливаа хэргийг эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баримтлан бусад хэргийн жишгээр шийдвэрлэж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл сэтгэл зүйн болон эдийн засгийн харилцан хамаарал бүхий хүмүүсийн хооронд үйлдэгддэг, хохирогч хүчирхийлэгчтэй нэг орчинд амьдарч түүний эрхшээлд байдаг төдийгүй, хүчирхийлэл нууц байдлаар удаан хугацааны туршид үргэлжилсэн шинжтэй үйлдэгддэг зэрэг өвөрмөц онцлогт нийцэхгүй байна.

Иймээс хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэж байгаа хариуцлага, арга хэмжээ нь хохирогчийн хохирлыг барагдуулах нь байтугай эргээд сөрөг нөлөө үзүүлэхэд хүрч байна. Ийм учир Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын практик, хандлага, улс орнууд энэ асуудлыг шийдвэрлэх талаар ямар хууль баталж, үйл ажиллагаа явуулж байгаа талаарх мэдээллийг төрийн шийдвэр гаргагч болон орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллагууд, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх явдал чухал байгаа юм.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудал нь асар их хор хохирол учруулж, хүний эрхийг ихээхэн зөрчиж, цаашлан аюултай гэмт хэрэгч үйлдэгдэхэд хүрч байгааг анхаарах цаг нэгэнт болжээ. Манай улсад албан бус судалгааны хүрээнд гурван гэр бүл тутмын нэгд гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр байгаа гэж үзэж байна.

#### **Судалгааны зорилго, зорилт:**

Хүний эрх тэр дундаа гэр бүлийн гишүүдийн эрх зүйн байдал гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох ямар сөрөг нөлөөтэй гэдгийг судалж хүний эрхэд ноцтой зөрчил бий болгож байгааг хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хандан эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хууль тогтоомж, хэрэгжилтийг хянах бүтэц, механизмыг судлан түүнийг хэрхэн үр нөлөөтэй болгох талаар санал гаргах гол зорилго тавьж байна.

#### **Зорилгын хүрээнд зорилт нь:**

**Дээрх зорилгыг дараах зорилтын хүрээнд судалсан болно.**

- 1.1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт
- 1.2. Гэр бүлийн хүчирхийлэл дэлхий дахинд тархсан байдал
- 2.1. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал
- 2.2. Гадаад орнуудын гэр бүлийн хүчирхийллийн байдал, түүний эрх зүйн



зохицуулалтууд түүнийг өөрийн оронтой харьцуулан үзсэн тухай

3.1. Гэр бүлдэх хүчирхийллийн тухай НҮБ-ийн зөвлөмж түүнд Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцсэн байдал

#### **Судалгааны арга, арга зүй:**

Энэхүү судалгааг хууль зүйн норматив болон, судалгааны ерөнхий арга болон харьцуултын аргыг ашигласан болно.

#### **Судлагдсан байдал:**

Гэр бүлийн хүчирхийлэл харьцангуй шинэ ойлголт бөгөөд энэ талаарх ойлголт иргэдийн дунд ховор төдийгүй уг асуудал нь өөрөө их зөрчилтэй байдалтай байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар НҮБ-н эмэгтэйчүүдийн хөгжлийн сан санхүүжүүлэн Иргэдийн Альянс төв, Хүний эрхийн хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвүүд судлагаа хийсэн байна. Мөн Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүний эрхийн үндэсний комисс энэ талаар судалгаа явуулсан байна.

### **Гэр бүлийн эрх зүйн зарим тулгамдсан асуудал**

#### **Нэгдүгээр бүлэг**

##### **1.1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт**

Хүний эрх гэдэг бол хүн болж төрснийхөө ачаар бий болдог, хүн бүрт заяасан эрх бөгөөд хүний эрхийн гэрээнд нэгдэн орсон, соёрхон баталсан аливаа улс орны төр засгийн газар хүний эрхийг хамгаалах, түүнд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд Монголчуудын дунд “гэр бүлийн хүчирхийлэл” гэсэн нэр томъёо харьцангуй танил сонсогдох болж энэ чиглэлээр иргэд, төрийн албаны ажилтанууд ярьж, бичих болжээ.

Түүгээрч барахгүй төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд ч гэр бүлийн хүчирхийлэлийн талаар төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах сонирхол өссөн байна.<sup>1</sup> Өртөгч субъектүүд нь ихэвчлэн бага насны хүүхэд, өндөр настангууд, эмэгтэйчүүд байдаг байна.

Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч хэрэглэн эрх мэдлээ давамгайлж, бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хувьд хохирол учруулж,

<sup>1</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтээ сурьдчилан сэргийлэх арга зам, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв, УБ2003 он Гэр бүлийнхүрээндэххүчирхийлэлхувьхүмүүсийнхоорондындотоодасуудал, зөвхөндтодтүвшний хүмүүсийн амьдралд байдаг мэтээр үздэг нийгмийн сэтгэл зүйд өөрчлөлт гарч байна.



доромжлон, хүч хэрэглэж байдаг гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэмд бодьтойгоор оршин хувь хүн, нийгмийн тодорхой хэсгийн эрх ашгийг зөрчиж байгааг гэр бүлийн хүчирхийлэл гэж тодорхойлсон байна.<sup>2</sup>

Гэр бүл дэх хүчирхийлэл нь хүний хувийн амьдрал, амин хувийн нууцтай холбоотой байдаг тул маш эмзэг асуудал.<sup>3</sup>

## 1.2. Гэр бүлийн хүчирхийлэл дэлхий дахинд тархсан байдал

➤ Дэлхий Банкны үнэлгээгээр, аж үйлдвэр хөгжсөн орнуудад ерөнхий үзүүлэлтээрээ 15-44 насны эмэгтэйчүүдийн үхлийн 19% нь хүчиндэлт болон гэр бүлийн хүчирхийлэлээс болсон байна. Энэ нь нас барж буй энэ насны 5 эмэгтэйн нэг нь хүчирхийлэлийн үйлдлийн үр дагавар болох бэртэл, өвчинөөр амь үрэгдэж байна.

➤ Англид 2000 оны 10 сард явуулсан судалгаагаар, 60 секунд тутамд гэр бүлийн хүчирхийлэлийн хэргээр цагдаа дууддаг байна. Цагдаа өдөрт 1300, жилд 570000 гаруй тооны гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой утасны дуудлагад хариу өгдөг байна.

➤ АНУ-д эмэгтэйчүүдийн 40% нь доромжлолд өртөж байна.

➤ Японы эмэгтэйчүүдийн 59% нь хамтран амьдрагчийнхаа зүгээс бие махбодийн хүчирхийлэлд өртөж байна. Японд улсын хэмжээний анхны санал асуулгын дүнд эмэгтэйчүүдийн 14% нь хамтран амьдарч байгаа залуудаа эмнэлгийн тусламж шаардлагатай болтол зодуулжээ.

➤ Энэтхэг болон Шири-Ланкад жил тутамд 5000 гаруй эмэгтэй инжнээс болж аллагын хохирогч болж байна. Энэтхэгт явуулсан социологын санал асуулгад 90000 энэтхэг эмэгтэй оролцжээ. Тэдний 56 орчим хувь нь гэр бүлийн хүчирхийлэлийн тодорхой нөхцөл байдалд байдаг гэжээ. Ер нь эмэгтэйчүүдийг буруутгаж болох 6 нөхцөл байдлын ядаж аль нэг нь заавал болж байдаг байна. Үүнд: хүүхдийг муу арчилсан, ажахиугаа муух өтлөх, хань ижилээсээ урвасан хэмээн сэжиглэгдэх, эцэг эхэд үл хүндэтгэл илэрхийлэх, хоол муу хийдэг гэх зэргээр.

➤ Статистикчдын үнэлгээгээр, дэлхийд жил тутам 600 сая эмэгтэй янз бүрийн хэлбэрийн доромжлол, хүчирхийлэлээс үүдсэн зуурдын үхлээс болж нас барж байна.

**Жишээ нь:** Орос оронд жил бүр 14000 орчим эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлээс болж нас барж байна. Харьцуулалт хийхэд Афганистан дахь дайны арван жилд 13000 мянга орчим Орос цэрэг нас барсан. 1997 онд Литвад 16-аас дээш насны эмэгтэйчүүдийн 63% нь эр нөхрийн зүгээс үйлдсэн бие махбодын буюу сексийн хүчирхийлэлийн хохирогч болсон байна. Тажикстанд эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд

<sup>2</sup> Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага Х.Виктор Кондэ.

<sup>3</sup> Annual Report on Equal Opportunities For Women and Men in the European Union 2000, Report From the Commission to the Council, the European Parliament



өртөж, эхнэрүүдийн 47 орчим хувь нь эр нөхөрийнхөө хүчиндэлтэнд өртсөн байна.<sup>4</sup> Харамсалтай нь, гэр бүлийн хүчирхийлэлд зааг хязгаар үгүй юм. Хүчирхийлэл хэмээх энэ нийгмийн энэ эмгэгийг үндсээр нь устгахад хүч чармайлтаа чиглүүлэх нь зүй ёсны асуудал болсон байна.<sup>5</sup>

## Хоёрдугаар бүлэг

### 2.1. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал

Монгол улсын Үндсэн хуулинд хүн бүр тэгш эрхтэй гэж тусгаж <sup>6</sup> өгсөн ба Хүний эрхийн түгээмэл тунхаглалын гуравдугаар зүйл Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.<sup>7</sup> Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактад энэ пактад оролцогч улсууд түүнд заасан иргэний болон улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эрх эдлүүлэх эрхтэй.<sup>8</sup> гэж мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад оролцогч улсууд арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал, нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр энэхүү пактад тунхаглан зарласан эрхийг хэрэгжүүлэх баталгаа гаргах нь зүйтэй.<sup>9</sup> гэж олон улсын гэрээ конвенцуудад тусгаж өгчээ. Монгол улсын Үндсэн хуульд олон улсын гэрээ хүлээсэн үүргээ өөрийн хууль тогтоомжын нэгэн адил дагаж мөрдөнө гэж заасан нь бодит байдал хэрэгжихгүй байна энэ бол Монгол улсын өнөөгийн байдал.

Гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол орны хувьд ч нэлээд түгээмэл байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд гарсан гэмт хэрэг, зөрчил гэр бүл, аж ахуйн хүрээнд үйлдэгдэх явдал өсөж байгаа нь гэмт хэрэг гарах орчин нууцлагдаж, аж ахуйн хязгаарлагдмал хүрээнд үйлдэгдэж байгааг нотолж байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг ихээхэн хохироож байдгаараа нийгмийн хамгийн эмзэг асуудлын нэг мөн.

Гэтэл хууль хяналтын байгууллагад мэдэгдээгүй, нууцлагдмал байдлаар үйлдэгдэж, үргэлжилсээр байгаа хүчирхийлэлийг бид бодиттоогоор, албан ёсоор хэлж чадахгүй байгааг бас харгалзан үзэх ёстой.

НҮБ-н Эмэгтэйчүүдийн сангаас явуулсан “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин, Монгол Улс” судалгаанд сүүлийн 3 жилийн байдлаар Улаанбаатар хотод

<sup>4</sup> Гэр бүл, ахуйн хүрээндэх хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, хууль тогтоомжыг боловсронгуй болгох асуудал П.Цэцгээ.

<sup>5</sup> Региональная информационная кампания ФНИФЕМ

<sup>6</sup> Монгол Улсын Үндсэн хууль УБ хот 1992 он

<sup>7</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал

<sup>8</sup> Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

<sup>9</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт



гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүчиндүүлсний улмаас 1037 охид, эмэгтэйчүүд шүүх эмнэлэгт хандсанаас 326 хэргийг нийслэл, дүүргийн шүүх шийдвэрлэжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл гарах шалтгааныг авч үзвэл гэр бүлийн хэрүүл маргаан 51,2%, хардалт 24,8%, архидалт 24%-ийг эзэлж байна.<sup>10</sup>

#### **А. Хүчирхийлэл үйлдэгчид:**

Улаанбаатар хотод гэр бүлийн хүрээнд гарсан гэмт хэргийн судалгаанаас үзвэл хүчирхийлэгч нь нөхөр 64.1%, салсан нөхөр 2.8%, хамтран амьдрагч 3.4%, үерхдэг найз 7.1%, эцэг 4.9% зэрэг байна.<sup>11</sup>

#### **Б. Насны байдлаар авч үзвэл:**

Хамгийн их хувийг 25-39 насныхан 44.2% эзэлж байгаа бөгөөд үүнээс 25-39 насныхан 20.9%-ийг, 30-34 насныхан 23.3%-ийг тус тус эзэлж байна. 40-өөс дээш насны эрчүүд бага бус хувийг эзэлж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэгч нь голчлон дунд орчим насныхан байдаг гэсэн дүгнэлт өгч боломгүй байна. Харин ахих тусам ухаан сууж байх хүмүүс эсрэгээр 25 наснаас дээш нас ахих тусам хувийн жин өсөх хандлагатай байна.<sup>12</sup>

#### **В. Боловсролын түвшингээр нь авч үзвэл:**

Гэр бүлийн хүчирхийлэгчдийн 33.4% нь бүрэн бус дунд, 31.6% нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Дээд боловсролтой хүмүүсийн дунд ч гэр бүлийн гишүүдээ дарамтлах, эхнэрээ зодох, хорьж цагдах явдал бодит амьдралд их байдаг. Судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас хохирогчдын талаас илүү хувь нь хүчирхийлэгчийн эхнэр, 10 орчим хувь нь ээж нь байна.<sup>13</sup>

#### **Г. Гэмт хэрэгт эзлэх хувь:**

Гэр бүлийн хүчирхийлэгчид эхнэр болон ээж, охин, найз бүсгүй, эгч дүүгийнхээ эрүүл мэнд, бие махбодид нь халдан амь насыг нь зэрлэгээр хохироох явдал шүүхийн шийдвэрлэсэнний тэрүүгийн гэмт хэргийн 50-иас илүү хувийг эзэлж байна. Үүнд: Бие махбодийн дарангуйллын цаана гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй бүх эмэгтэйчүүд сэтгэл санааны хохирол эдэлдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Эхнэр болон найз бүсгүй, охиноо алхаар буюу хүнд гэмтэл учруулахаар занал хийлэх, хэрцгий харьцсаны улмаас эхнэрийнхээ амь насаа хорлоход хүргэсэн гэмт хэрэгч гарсан байна.<sup>14</sup>

#### **Д. Шийтгэгдсэн байдал:**

<sup>10</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн тоо баримт, ХЭҮТ,

<sup>11</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин. Монгол Улс НҮБ-ийн эмэгтэйчүүдийн сан. УБ 2002 он

<sup>12</sup> "Хууль дээдлэх ёс" ХЭҮТ 2005 он

<sup>13</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин. Монгол Улс НҮБ-ийн эмэгтэйчүүдийн сан. УБ 2008 он

<sup>14</sup> "Хүний эрх ба хөгжил" сэтгүүл УБ 2001 он, №3



Улаанбаатар хотод хийсэн судалгаараар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэнийхээ төлөө шийтгэгдсэн байдлыг үзвэл хүчирхийлэгчдийн 50 гаруй хувь нь 0-2 жилийн хорих ялаар шийтгэгджээ. Засан хүмүүжил хийлгэх талаар 0.5% шийтгэгдсэн байна. Харин сүүлийн жилүүдэд 6-аас дээш жилээр хорих ял эдэлж байгаа нь онц ноцтой гэмт хэрэг, өөрөөр хэлбэл, Эхнэрийнхээ амь насыг хохироох, хүнд гэмтэл учруулах явдал ихэссэнтэй холбоотой байна. Гэр бүлийн байнгийн дарамтанд байх эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэх болсон байна. Хүчирхийлэл дарамтаас залхсан тэвчих аргагүй байдалд хүрч амь насыг нь хөнөөж 15-аас дээш хорих ял эдэлж байна.<sup>15</sup>

Гэр бүлийн хүчирхийлэлд ихэвчлэн хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд хохирч болж байгаа ба тэдний эрх ашгийг мөн хамгийн их зөрчиж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл юм. Учир нь хүчингийн гэмт хэргийн хуульчлагдаагүй хэлбэрүүд болох гэрлэгсдийн, ураг төрлийн болзооны хүчингийн өнөөгийн нөхцөл байдлыг сайн тодорхойлж үүнд доривтой арга хэмжээ авагдахгүй байна.<sup>16</sup>

Одоо хүртэл гэрлэгчдийн хүчин, болзооны хүчингийн талаарх хуулийн ойлголт тодорхойлолт гараагүй мөн гэрлэгчдийн хүчин гэсэн нэр томъёо огт байхгүй байна. Ураг төрлийн хүчин гэр бүлийн хүрээнд өргөн байдаг хэмээн судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 4 нь үзсэн бөгөөд хойд эцэг, дагавар охиноо хүчиндэх нь элбэг /76%/ гэж үзсэн байна. Хуулийн байгууллагуудын судалгаанд оролцогчдын үзсэнээр хүчингийн гэмт хэрэг гарах хамгийн гол үндсэн шалтгааныг бэлгийн боловсрол эзэмшээгүй явдал /90,7% гэж тодорхойлсон байна. Энэ нь бэлгийн боловсролын талаар мэдлэг дээшлүүлэх сургалт дутагдаж байгаагын нэг илрэл мөн юм.<sup>17</sup>

## **2.2. Гадаад орнуудын гэр бүлийн хүчирхийллийн байдал, түүний эрх зүйн зохицуулалтууд түүнийг өөрийн оронтой харьцуулан үзсэн тухай**

Өрнөдийн ардчилсан орнуудад гэр бүлийн хүчирхийлэлийн асуудлыг дуугүй өнгөрөөхөө больж улс төрийн шинжтэй хэлэлцэх асуудлын тоонд оруулах үйл явц 70-аад онд феминистүүд, олон нийтийн идэвхтэнүүд, гэр бүлийн хүчирхийлэлд хохирогч эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь хамтын үйл ажиллагааны чармайлтын үр дүнд бий болсон байна.

1990 оноос бүх дэлхийн улс орнуудын засгийн газрууд гэр бүлийн хүчирхийлэлийг нийгмийн “ноцтой асуудал” хэмээн хүлээн зөвшөөрч, түүнийг шийдвэрлэх арга зам хайж эхэлсэн. Дэлхийн олон оронд гэр бүлийн хүчирхийлэлийн талаар явуулсан судалгаанаас тоо баримт нь ихэнх тохиолдолд эмэгтэйчүүд хүчирхийлэлийн хохирогч болдог гэдгийг

<sup>15</sup> “Хүний эрх ба жендэр” ХЭҮД, УБ 2002

<sup>16</sup> Хүчингийн гэмт хэргийн хуульчлагдаагүй хэлбэрүүд “Судлаач Л.Бадамцэцэг, ХЭҮТ-ийн ажилтан

<sup>17</sup> Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын хэрэгцээ ХЭҮТ-ийн ажилтан Ч.Гэрэлмаа



баталсан байна. **Жишээ нь:**

Их Британид бие хүний эсрэг гэмт хэргийн 25 хүртэлх хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байна. Мөн түүгээр барахгүй зөрчилийн талаарх цагдаагийн дуудлагын бараг 90 хувь нь нөхөр нь эхнэрээ, найз залуу нь найз охиндоо гаргасан түрэмгий зангийн дуудлага байсан нь илэрчээ.<sup>18</sup>

Өнөөдрийн байдлаар, дэлхийн 40 гаруй улс орон гэр бүлийн хүчирхийлэлийг хоргилсон ямар нэгэн хуультай байна. Дэлхий дахины туршилгаас асуудлыг хууль тогтоомжын замаар шийдвэрлэвэл ихээхэн үр дүнтэй байдаг. Гэхдээ олон улсын практикт авсан нэн чухал санамжууд.

1.Тусдаа бие даасан хууль байх нь илүү үр ашигтай. Хууль нь үйлчилдэггүй, де-юребаде-фактогийн хооронд ихээхэн хийдэлтэй орнуудад бас нэг ажиллагүй хууль гаргах нь утга учиргүй гэсэн санал байдаг. Харин хууль ядахдаа “бэлэг тэмдэг” болоод ч гэсэн байж байх нь гэр бүлийн хүчирхийлэлийн талаарх мэдлэгийгн эмэгдүүлж мөн гэр бүлийн хүчирхийлэлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж тэр дундаа тусдаа хууль байх нь энэ асуудлыг байгааг хүлээн зөвшөөрч байгаагаараа тус нэмэр болж мэдлэг дээшлэх, гэр бүлийн хүчирхийлэлээс болж хохирогсдод хүчирхийлэлтэй тэмцэх арга замыг нь зааж өгдөг.

2.Тусад нь хууль боловсруулж гаргахын өмнө хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нэлээд их боломж байдаг. Үүнтэй холбогдсон, Тусгаар тогтносон орнуудын Холбооны гишүүн орнуудад өнгөрсөн үеэсээ залгамжлан авсан хууль зүйн хэрэгсүүлд бий. Жишээ нь олон улсын шинжээчдийн саналаар, чадварлаг хэрэглэвэл гэр бүлийн хүчирхийлэлийг багасгахад нөлөөлж чадах захиргааны баримчлах арга хэмжээ байна.<sup>19</sup> Лондоны их сургуулийн экологи, нийгмийн шинжлэх ухааны факльтетын дэргэдэх хүүхэд, эмэгтэйчүүдийн талаарх хүчирхийллийг судлах Нэгдлийн профессор Лиз Келлийн тэмдэглэн хэлснээр хуулиуд чиглэлээрээ ялгаатай байдаг гэжээ. Тэрээр ингэж бичсэн байна.<sup>20</sup>

➤ Зарим хууль анхны удаа үйлдсэн эрх зүйн зөрчилд хамгаалалтын шийдвэр хэрэглэх боломжтой иргэн-эрх зүйн арга хэмжээгээр хязгаарлагдаж /Финлянд, Испани/ эсвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэмээн буруутгагдсан этгээдийг хүүхдүүдтэйгээ харьцахыг нь хязгаарлах арга хэмжээгээр хязгаарлагддаг.

➤ Өөр бусад хуулиуд хамгаалалтын шийдвэр хэрэглэх боломж ба дотоод хэрэг эрхлэх байгууллагуудын бүрэн эрхийг өргөтгөсөн. /Австри, Ирланд/

➤ Зарим хуулиуд иргэний байцаан шийтгэх болон эрүүгийн байцаан шийтгэх арга

<sup>18</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн бүх хэлбэрийг устгах судалгаа УБ 2007 он

<sup>19</sup> Гадаад орнууд дахь гэр бүлийн хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалдын байдал. Х.Оюунцэцэг

<sup>20</sup> Western stantarts for fost communist women Equal Opportunities for Women and Men.



хэмжээнүүдийг нэгтгэн нийлүүлсэн /Кипр, Мексик, Никарагуа, АНУ-н зарим муж улс/

➤ Зарим хуулиуд эрүүгийн шинэ хэргүүдийг оруулсан буюу гэр бүлдээ үйлдсэн гэмт хэргийн төлөөх ял шийтгэлийн арга хэмжээг цуцалсан /Бельги, Франц, Испани, Швед/

➤ Нөгөө зарим хуулиуд нь хуульд хэрхэн өөрчлөлт оруулахыгч, төрөөрөө тусламжын алба байгуулах, мөн түүнчлэн төрийг ашиглан төрийн нэрийн өмнөөс хүчирхийлэл үйлдэх үйлдлийг ор мөргүй арилгах, мөн урьдчилан сэргийлэх төсөлд хөрөнгө мөнгө гаргах тухайд хүлээх хариуцлагыг ч тусгаж өгсөн“ цомхон хуулиуд “байдаг / Кипр, Австри, Дани, Финялнд, Швед/

Мөн Шинэ Зеланд, Австри хоёр улс нь гэр бүлийн хүчирхийлэлийн тухай нэлээд “шинэтгэн сайжруулагч” хуультай ажээ. “Австрийн хууль, цагдаагийн байгууллагадаа, хэрвээ үнэхээр гэмт хэрэг үйлдсэн, мөн давтагдаж болзошгүй гэж үзэх бүхийл үндэслэл байгаа бол хүчирхийлэлийн нөхцөл байдалд гэм буруутай этгээдийг 10 хүртэлх хоног хорих бүрэн эрхийг олгосон. Үүний дараа эмэгтэйчүүд энэ хугацааг сунгуулахаар шүүхэд хандаж болно.”<sup>21</sup> /Энэ хууль нь хохирогч эмэгтэйчүүд нь сэтгэл зүйн зөвөлгөө авах тусламж хүртэж харин эрэгтэйчүүд нь албадлагаар гэртээ эзгүй байх үедээ засан хүмүүжүүлэх курсэд сууж болох хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх төслийг хэрэгжүүлэхийг тусгаж өгчээ./ Шинэ Зеландын хууль, шүүхээс, хохирогч болон хүүхдүүдтэйгээ харьцах нь аюулгүй гэдгийг тогтоох хүртэл түрэмгийлэгч хохирогч болон хүүхдүүдтэйгээ харилцаа холбоогүй байх зайлшгүй шаардлагатай гэдгийг дурдаж өгснөөрөө давуу талтай.

Бельги /1997/, Франц /1994/, болон Испани /1999/ гэсэн улс орнууд хууль тогтоомжиндоо гэрийн нөхцөл байдалд хүчирийлэл үйлдсэний төлөө илүү хатуу чанга ял шийтгэлийг тусгаж өгчээ

### Гуравдугаар бүлэг

#### 3.1. Гэр бүлдэх хүчирхийллийн тухай НҮБ-ийн зөвлөмж түүнд Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцсэн байдал

Доорх загвар хуулийг өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн болон иргэний хууль тогоомжуудын боловсронгуй бус байдлыг өөрчлөн сайжруулах буюу гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиудыг боловсронгуй болгох зорилготой. Уг загвар нь хууль тогтоох байгууллагууд болон гэр бүлийн хүчирхийлэлийн салбарт хүйсийн өвөрмөц онцлогыг тусгасан, хүчирхийлэлтэй холбоотой бүх асуудлыг багтаасан хууль тогтоомж гаргахын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад НҮБ-ээс зориулан гаргасан

<sup>21</sup> Annual Report on Equal Opportunities For Women and Men in the European Union 2000 ,Report From the Commission to the Council, the European Parliament



байна. Энэ зөвлөмж хууль манай улсын гэр бүлийн хүчирхийлэлийн хуулинд хэр зэрэг тусгагдсан талаар харьцуулан хархад доорх дүгнэлт гарч байна.

### **А.Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн зорилго**

1.Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх явдлыг үндсээр нь устгах тухай НҮБ-ын Тунхаглалд “эмэгтэйчүүдийг хүчирхийлэх гэдэг нь эмэгтэйчүүдэд бие махбодь, бэлгийн буюу сэтгэл санааны гэм хор буюу зовлон шаналал учруулж буюу учруулж мэдэх, бэлгийн харьцааны шинжтэй үндэслэлээр үйлдсэн хүчирхийллийн аливаа үйлдэл, мөн ийм үйлдэл хийхийг занал хийлсэн, албадсан, нийгмийн буюу хувийн амьдрал дахь эрх, эрх чөлөөг дур мэдэн хасах явдал мөн , хэмээн тодорхойлсон стандартыг сахин мөрдөхөд тустай гэжээ.

2.”Эмэгтэйчүүд, тэр дундаа гэр бүлийн гишүүд буюу гэм хор учруулагч этгээдтэй ойр дотны харьцаатай эмэгтэйчүүдийг бэлгийн харилцааны шинжтэй үндэслэлээр хүчирхийлсэн үйлдэл бол гэр бүлдэх хүчирхийлэл мөн”гэдгийг хүлээн зөвшөөрөх.

3.”Гэр бүлийн хүчирхийлэл бол бие хүн болоод нийгмийн эсрэг, уучлашгүй, тэвчишгүй ноцтой гэмт хэрэг мөн” гэдгийг хүлээн зөвшөөрөх.

4.Хүчирхийлэл хохирогчдыг хамгийн дээд хэмжээний эрх зүйн хамгаалалтаар хангах. Гэсэн заалтуудыг голлон авч бичлээ.<sup>22</sup>

### **Б.Зохицуулвал зохих харилцааны хүрээ**

1.Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хуулийн үйлчилэх хүрээнд дараах категориудын харилцааг оруулсан болно: эхнэр, хамтран амьдрагч, өмнөх эхнэр буюу хамтран амьдрагч, хамтран болон тусдаа аж төрдөг төрөл төрөгсөд, эгч дүүс, охид, эхчүүд, мөн гэрийн үйлчлэгч болон тэдний гэр бүлийн гишүүд.

2. Шашны буюу соёлын зан заншил нь хэн нэгэн эмэгтэйд тухайн хуулийн хүрээнд бүрэн хамгаалалт авахад нь саад болохыг Төрөөс зөвшөөрөх ёсгүй.

3.Хань нөхөр эсвэл ойр дотны харилцаатай өөр бусад этгээдийн талаар шүүх байгууллагад хандахыг хүссэн эмэгтэйд ямарч саад тотгор учирах ёсгүй.

4.Төрөөс тухайн хуулийн хүрээнд, тухайн улсын иргэний харъяалалгүй эмэгтэйчүүдэд бүрэн хамгаалалт олгох, мөн тухайн хуулиар, тухайн улсын иргэн бус эрэгтэйчүүдэд хуулийн хариуцлага ноогдуулах ёстой.

### **В.Гэр бүлдэх хүчирхийллийн шинжтэй үйлдэлүүд**

Гэр бүлийн болон ойр дотны харилцаатай этгээд буюу этгээдүүд бэлгийн харьцааны шинж бүхий үндэслэлээр үйлдсэн, бие махбод, сэтгэл зүйн болоод бэлгийн харьцааны шинжтэй, хэл амаар доромжлох, айлган заналхийлээс эхлээд бие махбодид хүнд гэмтэл

<sup>22</sup> Western stantarts for fost communist women Equal Opportunities for Women and Men. Annual Report on Equal Opportunities For Women and Men in the European Union 2000 ,Report From the Commission to the Council, the European Parliament



учруулах, хулгайлах, бэртээж гэмтээхээр заналхийлэх, албанг сүрдүүлэх, албадах, мөрдөж мөшгөх, хэл амаар доромжлох, орон байранд хүчээр буюу хууль бусаар нэвтрэн орох, шатаах, өмч хөрөнгө устгах, бэлгийн хүчирхийлэл, хүчээр гэр бүл болох, сүйт бүсгүйн инж сүй буюу төлөөстэй холбоотой хүчирхийлэл, бэлэг эрхтэнг бэртээж гэмтээх, янхандах замаар ашиглахтай холбоотой хүчирхийлэл, гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэлх, хүчирхийлэлийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг “гэр бүл дэх хүчирхийлэл” гэж үзэх ёстой. Манай улсад мөн энэ талаар тодорхой нарын зааж өгөөгүй байгаа юм.

### Г.Гомдол гаргах механизм

Хүчирхийлэлийн хохирогчид, тэдний гэр бүлийн гишүүд, хүчирхийллийн гэрч, хүчирхийлэлийн хохирогчдын ойр дотнын хүмүүс, хүчирхийлэлийн хохирогчдод хоргодох байраар үйлчилсэн этгээдүүд, төрийн болон хувийн эмнэлгийн байгууллагууд, нийгмийн алба, хүчирхийлэлийн хохирогчдод тусламж үзүүлэх төвөөс гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаад гомдлоо бүртгүүлэх эсвэл шүүхэд өргөдөл өгөх журмыг хуулинд тусгасан байх ёстой. Харамсалтай өнөөдөр манай гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд нарын тодорхой огтхон ч зааж өгөөгүй бөгөөд цагдаагын байгууллагын үүргийг л оруулж өгсөн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд дотоодын эрх зүйн орчин чухал үүрэгтэй бөгөөд шинэ тусгаар тогтносон орнууд шилжилтийн үед хийсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд энэ асуудлыг хийх хэрэгтэй байна. Эрх зүйн шинэчлэл, нийгмийн тулгамдсан асуудлыг зохицуулалтын хүрээнд зарим орон эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахад чиглэгдсэн төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй байна.<sup>23</sup>

### Дүгнэх буюу санал

Дээрхи харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд дараах зүйлийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүйсээр тодотгосон хүний эрх, халдашгүй байдлын асуудлууд зөрчигдсөн хэмээн дуулдах нь тун ч олон. Тухайлбал, нөхөртөө дарлуулсан эмэгтэй, хүчинд автсан бүсгүй гээд энэ сэдвийн гол хохирогч нь эмэгтэйчүүд байдаг. Охид бүсгүйчүүдийн байгалиас заяагдсан мөн чанар нь эмзэг турьхан төдийгүй гэнэн итгэмтгий байдаг нь үнэн. Байгалиас заяасан уг чанар нь нэг талаас хүчирхийлэлд өртөх өгөөш болдог. Нөгөө талаас эрчүүдээс ялгарах ялгуун төрх юм. Түүний дотор эмэгтэй хүн болгон өөрийн гэсэн ааш, зүс царайтай. Харин дээр дурьдсан хүчинд өртөмтгий сул тал бол баян, ядуу, тарган, туранхай бүх эмэгтэйд байдаг шинж.

Манай оронд охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах газар олон бий ч эрчүүдийн эрхийг хамгаалах газар гэж бараг дуулдаагүй. Байдагч юмуу? Үгүйч юмуу ёстой чөтгөр

<sup>23</sup> Гэр бүлийн эрх зүйн байдлыг шинэчлэх зарим асуудал УБ 2009 он



бүү мэд. Байдаг байсан ч үйл ажиллагаа нь тогтвортой биш хийгээд онцын нэмэргүй гэж эрчүүд маань хэлэх юм. Манай орны хувьд нийт хүн амын 70 орчим хувь нь эмэгтэйчүүд, харин үлдсэн нь эрэгтэйчүүд шүү дээ. Дийлэнх болсон эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж байгаа тохиолдол олон байгаа учраас хамгаалах байгууллагууд ч нэлээд бий. Хамгийн сүүлд хийгдсэн судалгаагаар манай эмэгтэйчүүдийн 18-35 насныхан хүчирхийлэлд өртөх нь элбэг гэж тогтоогдсон байна.

Манайхан хүчирхийлэл гэхээр бэлгийн талаас нь ойлгодог. Үүнийг буруутгах арга ч үгүй юм даа. Хүчирхийлэлд өртөж байгаа эмэгтэйчүүдийн 50-аас дээш хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. 90-ээд оны үед нөхрөөсөө жавтгий хүртэх хүүхнүүд олон байсан бол 2000 он гарсаар бэлгийн хүчирхийлэл тэр дундаа ажлын байрны бэлгийн дарамт шахалт газар аван хүрээгээ тэлсээр байна.

Бичих гэж байсан сэдвээсээ бүр хазайж орхилоо. Яншаа занг минь өршөө. Энэ удаад эрчүүдээ өмөөрөх гэж байсан юм. Дээр бичсэнийг уншсан эрчүүд маань нэгийг бодохгүй юу даа. Айлын охиныг жаргаанаа хэмээн найрж авсанаа нэг санаарай. Харин одоо эрчүүд хүчирхийлэлд хэр өртөж байна? Энэ сэдвийн хүрээнд өөрийн бодол, олж мэдсэнээ хуваалцъя. Би эрэгтэй ахтайгаа ярилцлаа. Ах маань 38 настай. Жирийн нэгэн сайхан залуу.

❖ **Судлаач:** Танай эхнэр танийг алгадаж байсан уу?

**Ах:** Харин тийм, үе үе сарвайгаад л байдаг юм. Уур хүрээд л явчихдаг юм.

Энэ бол би ахтайгаа ярьсан богино яриа байлаа. Энэ маягаар 21-50 насны 70 –аад орчим эхнэртэй, 2-оос дээш жил үерхсэн найз бүсгүйтэй эрэгтэй найзуудаасаа асуугаад л байлаа. Миний найзууд гэхээр яахаараа ийм дарлуулчихсан байдаг юм.

Арай ч дээ гэж сэтгэл баахан хямарлаа. Өмөөрмөөр санагдчихлаа шүү. Юуны тулд хуулийн сургуульд сурдаг билээ. Тэгээд багш, эдийн засагч, хуульч, жолооч, гээд л тэрч бүү хэл төрийн алба хаагч танихгүй олон эрчүүдээс асуулаа. Тэгсэн яасан гээч, ёстой баларсан юм болсон. Бүгдэд нь эмэгтэй хүн ямар нэгэн байдлаар халдаж эрхийг нь зөрчсөн байгаа юм даа. Хор нөлөө их үзүүлж чадаагүй ч тухайн хүний амгалан байдалд халдаж, алгадах, хүзүү нүүрийг нь самардах, маажих, өшиглөх, бүр аймшигтай нь архи ууж агсан тавих эхнэр хүртэл байдаг юм байна. Архичин ээжээсээ айгаад аавынхаа ард нуугдсан уйлагнах хүү хичнээн өрөвдөлтэй вэ? Сайхан бүсгүйчүүд минь ээ, бодоод үз дээ.

Чиний хайртай залуу чамайг алгадаад авбал чи яах вэ? Сарвагнах нь сарвагнаж, салах нь сална. Үгүй юмаа гэхэд нэг хэсэгтээ тунирхаж айлгана биз дээ. Тэгсэн хэрнээ эр нөхрөө, хайртай залуугаа алгачихаад өөрөө тунин сууна гэдэг чинь сүүтэй сахартай цай шиг нялуун санагдаж байна. Үүнийг сэтгэл судлал талаас нь ингэж тайлбарладаг юм байна. Эмэгтэйчүүд эрчүүдээс угаас хүч сул. Гэсэн ч эрчүүдээс дутахгүй, доор нь



орохгүй гэсэн далд ухамсар эмэгтэйчүүдэд байдаг юм байна л даа. Хэрүүлийн оргил шатанд уурандаа шатаад далд ухамсараа “Би чамаас мундаг илүү, бас хүчтэй” гэж бүсгүйчүүд цээжээ дэлдэн аавын хүүгийн хацар дээр тас хийтэл цохино.

Нэг талаас эрчүүдийн доор орох дургүйдээ ийм ухамсаргүй алхам хийдэг байх. Нөгөө хэсэг нь энэ намайг яаж ч чадахгүй гэж бат итгэгсэд хумсаа хурцалдаг байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр тэр танд хайртай, та ч бас түүнд хайртай гэсэн үг. Хайрын бэлгэ тэмдэг хүчирхийлэл гээд ойлгочихов доо, та нар минь. Тэгэхлээр бүсгүйчүүд ч гэсэн эрчүүдээ хүчирхийлдэг байх нь. Хатууг зөөлөн иддэг. Эрчүүдээ, бүсгүйчүүдээ ойлгомжтой тийм ээ. Ямар ч эмэгтэйтэй суусан хүчинд өртөх юм байна гэж сэтгэлээ бүү чилээ дээ, залуу минь. Салаад бас алгадахгүй эмэгтэй олно гэж сэрүүн битгий зүүдлээрэй.

**Дараах саналуудыг дэвшүүлж байна.**

1. Гэрлэгсдийн хүчин, болзооны хүчингийн талаарх хуулийн ойлголт тодорхойлолтыг гаргах, мөн Улсын дээд шүүхийн тайлбарт оруулах.

2. Манай улсын гэр хүчирхийллийн хуульд хүчирхийллийн хэлбэр гэж оруулж өгсөн ба тайлбар хийгээгүй байна. Сэтгэл зүйн хүчирхийлэл огт байдаггүй ба энэ талаар Украин улсын гэр бүлийн хүчирхийлэлийн хуулинд тодорхой оруулж өгсөн байна. Үүнд гэр бүлийн нэг гишүүний үйлдэлтэй холбогдон гэр бүлийн нөгөө гишүүний сэтгэлд зүйд нөлөөлсөн үгээр гутаан доромжлох, заналхийлэх, мөрдөн мөшгих, айлган сүрдүүлэх замаар өөртөө итгэх итгэлгүй болгох, өөрийгөө хамгаалах чадваргүй болгох, сэтгэл зүйн эрүүл мэндэд нь хохирол учруулж болох буюу учруулсныг гэж тодорхой заажээ.

Мөн гэр бүл дэх бие махбодийн хүчирхийлэл, гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл, гэр бүл дэх эдийн засгийн хүчирхийлэл, гэр бүл дэх сэтгэл зүйн хүчирхийлэл зэрэг тодорхойлолтуудыг хийж өгөх.

**Жишээ нь:** гэр бүл дэх бие махбодийн хүчирхийлэл гэдгийг гэр бүлийн нэг гишүүн нөгөө гишүүний зодох, хохирогчыг үхэлд хүргэж болох буюу үхэлд хүргэсэн бие махбодийн гэмтэл санаатай учруулсан, бие мах болон сэтгэл зүйн эрүүл мэндийг нь хохироосон, нэр төр, алдар хүндийг нь гутаасныг,

**Жишээ хоёр:** гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл: гэр бүлийн нэг гишүүн нөгөө гишүүнийхээ бэлгийн халдашгүй байдалд хууль бусаар халдах, түүнчлэн гэр бүл дэх насанд хүрээгүй гишүүнийг эсрэг бэлгийн чанартай арга үйлдэл.

**Жишээ гурав:** гэр бүл дэх эдийн засгийн хүчирхийлэл: гэр бүлийн нэг гишүүн нөгөө гишүүнийхээ орон байр, хоол хүнс, хувцас хунар бусад эд хөрөнгө буюу хэрэгслүүдээс санаатайгаар салах, тэдгээрт хохирогч хуулиар тогтоосон эрхтэй, энэ түүнийг үхэлд хүргэж болох, бие махбод болон сэтгэл зүй эрүүл мэндэд нь нөлөөлснийг.

**Жишээ дөрөв:** Гэр бүл дэх сэтгэл зүйн хүчирхийлэл: гэр бүлийн нэг гишүүний



үйлдэлтэй холбогдон гэр бүлийн нөгөө гишүүний сэтгэл зүйлд нөлөөлсөн үгээр гутаан доромжлох, заналхийлэх, мөрдөн мөшгих, айлган сүрдүүлэх замаар өөртөө итгэх итгэлгүй болгох, өөрийгөө хамгаалах чадваргүй болгох, сэтгэл зүй эрүүл мэндэд нь нөлөөлснийг .

**3. Family Court- Гэр бүлийн шүүх-Монгол улсын Үндсэн хуулинд тусгай шүүхүүдийг байгуулж болно гэсэн заалт бий.**<sup>24</sup> Энэ ч үүднээс гэр бүлийн тусгай шүүхийг байгуулах боломж нь хуулиар нээлттэй болж байгаа юм. Гэр бүлийн дотоод асуудал гэсэн нэрийн доор хүчирхийлэл үйлддэг байдлыг таслан зогсооход ийм шүүхийн гол зорилго чиглэгдэж байгаа. Гадны олон оронд энэ төрлийн шүүх байдаг ажээ.

4. Монголын улсын гэр бүлийн тухай хуульд “сэтгэлийг” хуульчилж өгөх ёстой. Материаллаг байдал хуульчилж байгаа нь үр дүнд хүрэхгүй байна. Энэ бүх гаж буруу шалтгаан нь харилцаа холбоогүй байдал, хүмүүжлийн доголдол, дутмаг хайр энэрэл, ирээдүйдээ сэтгэл зовсон байдал гэх мэт олон зүйлээс хамаардаг.

5. Манай улсын хүн амын насны бүтэц идэршиж байгаатай холбоотойгоор дунд насны гэр бүлийн тоо өсөн Монгол гэр бүлийн цөмийг бүрдүүлэх хүн ам зүйн тооцоо байгаа тул нийгэм эдийн засгийн эерэг сөрөг үр дагавруудыг урьдчилан харсан гэр бүлийн бодлого, үйл ажиллагааг боловсруулан төрөөс явуулах шаардлагатай байна. Гэр бүлд байнга тулгарч байдаг эдгээр бэрхшээлүүдээс үүдэн дийлэнх гэр бүлийн дотор байнгын хэрүүл маргаан, хөрөнгө мөнгө, эрх мэдэл, албан тушаал боловсролын ялгаа, хамаатан садан эцэг эх, ах дүүгийн дарамт, архидалт, ажилгүйдэл, хүчирхийлэл, гэр бүл салалт зэрэг олон сөрөг үр дагаварууд гарах болсон байна. Улс орнуудын нийгмийн хөгжил нь гэр бүлээс, гэр бүлийн хөгжил нь хүнээс, хүний хөгжил нь хүүхдээс шууд хамаарах болсноор гэр бүлийн ариун байдал, үнэт зүйлс, ёс билэгдэл, дэг журам зэрэг нь нийгмийн төдийгүй, хүүхдийн хөгжилд чухал байр суурийг эзлэх болсон нь харагдаж байна. Тиймээс гэр бүл болоход тохиромжтой насыг хуулинд нэмэж оруулах цаг иржээ. Насны доод хязгаарыг 21 насаар хуульчилж өгөх. Төлөвлөөгүй балчиг гэрлэлт ирээдүйн үр хүүхдийг өнчрүүлсээр байгааг та бүхэн бодох цаг болсон.

6. Гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэлх, хүчирхийллийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг “гэр бүл дэх хүчирхийлэл” гэж үзэх ёстой. Энэ талаах НҮБ-ийн зөвлөмж хуулинд оруулж өгсөн байх ба энэ нь хүний эрх талаасаа мөн орчин үеийн гэр бүлд байдаг асуудал үнэхээр гэрийн үйлчлэгч, асрагч хүмүүс гэр бүлийн гишүүнд тооцогдох ёстой хэдийгээр цусан төрлийн холбоогүй ч гэсэн учир хэрэв сул орхигдвол тэр хүмүүсийн эрхийг хамгаалж чадахгүйд хүрнэ.

<sup>24</sup> Монгол улсын хууль “Үндсэн хууль” УБ хот 1992 он

Дөчин долдугаар зүйл

3. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Дөчин наймдугаар зүйл

1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.



7. Гэр бүл ахуйн хүчирхийллийн эсрэг хууль батлах санал: Энэ санал нь илүү өргөн утгыг агуулсан ба гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг үндсээр нь өөрчлөх гэж ойлгож болох юм. Энэ хууль батлагдах шаардлага зүй ёсоор гарч ирсэн байна.

**Үүнд:** Юуны өмнө хуулийн зохицуулалтад хамрагдах субъектын хүрээг өргөн болгох. а.гэр бүлийн гишүүн, б.садан төрөл, в.хамтран амьдрагч гэсэн байдлаар учир нь гэрийн үйлчилэгч, хажуу өрөө хөлслөн суугч, гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдрагчид, гэр бүлээ цуцлуулсан бөгөөд хамт буюу тусдаа амьдарч байгаа боловч салсан нөхрийн зүгээс хүчирхийлэлд өртөгчид зэрэг нь гэр бүлийн гишүүн гэдэг нэр томъёонд хамаарахгүй байна.

Мөн энэ хуульд шүүх эрх мэдлийн байгууллагууд, төрийн бус байгууллагын эрх, үүрэг, иргэдийн оролцооны асуудлыг нарывчлан тусгавал зохистой.

**Үүнд:** Тусгаарлах шийдвэрийг шүүх:

а. Зөрчил гаргасан тохиолдолд

б.Шүүхээр хэрэг хэлэлцэгдэх явцад.

в.Хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх үе шатуудад гаргаж байхаар заасан.

Өөрөөр хэлбэл заавал гэрлэлт цуцлуулах тухай зэрэг нэхэмжлэл гарсан байхыг шаардахгүй гэсэн байдлаар.

**Нэгдүгээр бүлэгт:** “Нийтлэг үндэслэл”

- Хуулийн зорилт

- Хамрагдах этгээдүүд

- Зарчим, хуулийн нэр томъёо

**Хоёрдугаар бүлэгт** “Нийгмийн алба, түүний үйлажиллагааны чиглэл”

**Гуравдугаар бүлэгт**

- Гэр бүл, ахуйн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо эрх үүрэг.

**Дөрөвдүгээр бүлэгт:**

- гэр бүл, ахуйн хүчирхийлэлд өртсөн хохирогчын эрх, хамгаалах эрх зүйн арга хэлбэрүүд

**Тавдугаар бүлэгт:** Бусад зүйл гэсэн бүлгүүдтэй байвал зохино.

Энэ хуулийн санал гаргахад дараах зүйлс дээр анхаарав:

• Гэр бүл, ахуйн харилцааны хүрээнд эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд захиргааны



арга хэмжээг хянан ба торгууль хүлээлгэх хариуцлагыг хасах, учир нь зөрчил гаргагч этгээдэд торгууль хүлээлгэх хариуцлага ноогдуулсан тохиолдолд эмэгтэй хүн, хүүхдүүд зовж шаналах нь илүү олонтой байдаг.

- Өргөдөл хүлээн авахаас татгалзсаных нь төлөө албан тушаалтанд захиргааны хариуцлага тооцох.

- Гэр бүл дэх эрх зүйн зөрчилийг үнэлэхдээ олон нийтийн үйл ажиллагаанд аюул эс учруулах ач холбогдол багатай байх гэсэн ойлголтыг хасах, учир нь хууль хамгаалах байгууллагууд заримдаа энэ үндэслэлд хөтлөгдөөд хохирогчид эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг.

**8. Төрийн хяналтын түвшинд:** хүчтэй хэрэгсэл болох мэргэжлийн хяналтын тогтолцооноос нь төрөөс хүний эрхийг хангаж, баталгаажуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлж чадаж байгаа эсэхийг огт хяндаггүй нь ноцтой дутагдал юм. Хэдийгээр хууль тогтоомж, стандартыг төрийн үйлчилгээнд дагаж мөрдөж байгаа эсэхийг мэргэжлийн хяналтаар шалгаж, үнэлдэг боловч хүний эрхийг хамгаалах, хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар төрийн үйлчилгээний тодорхой стандарт, журам, хуульчилагдсан үйл ажиллагаа байхгүй байгаагаас мэргэжлийн хяналтын институтыг хүний эрхийг хамгаалах асуудлаар хууль тогтоомжын хэрэгжилтийг хянах боломжгүй болгожээ. Хэдийгээр хүний эрхийг хангах, баталгаажуулах асуудлаар дагнасан хууль тогтоомж батлагдан үйлчилж байгаа боловч эдгээр хуулийг хэрэгжүүлэх хэрэгжилтэнд хяналт тавих төрийн механизм нь хангалттай хуульчлагдаагүй байна.

Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүний эрхийг хангах чиглэлээр хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд байгууллагын дотоодод хариуцлага тооцох механизм бүрдүүлэх.

Цагдаагын байгууллагын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулах.

**9. Шүүхийн хяналтын түвшинд:** Хүний эрхийг хангах үндсэн баталгаа болох шүүхийн хяналтын тогтолцоо нь эмэгтэйчүдийн хүчирхийлэлтэй холбоотой, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хянах тал дээр туйлын хангалтгүй байна. Учир нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжын хүрээнд гэмт хэргийн шинжгүй хүчирхийлэлийг эрх зүйн зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ огт байхгүй байгаа нь шүүх эрх мэдлийн байгууллагаас хүчирхийлэлтэй тэмцэх, хууль сахиулах байгууллага хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжыг хэрэгжүүлж байгаа эсэх боломжыг үгүйсгэж байна. Иймд хариуцлагыг тодорхой болгох зайлшгүй шаардлага байна.

**10. Шүүхийн хяналттай холбоотой өөр нэг бэрхшээл бол** Үндсэн хуулийн цэцэд хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол хүлээн авч шийдвэрлэдэггүй явдал юм.



Дэлхийн бусад орны жишгээс авч үзвэл төрийн байгууллага, албан тушаалтанаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар иргэд үндсэн хуулийн шүүхэд гомдол гарган шийдвэрлүүлдэг байна. Харин манай улсад ийм боломжгүйн улмаас төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах үүргээ биелүүлээгүй тохиолдолд тавих хяналтын хүчтэй механизмгүй болоод байна.

Цоожтой хаалганы цаадах хүний эрхийн том зөрчил бол гэр бүлийн хүчирхийлэл юм. Эрх зүйг төр хөгжиж буй манай улсад иргэн бүрийн хууль ёсны эрх ашиг сонирхол хөндөгдөхгүй байх цаг ирнэ гэж итгэж байна.